



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 05 өдөр

Дугаар А/95

Бодь

「 2023 оны Газар зохион байгуулалтын
төлөвлөгөөний төсөл боловсруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, Захиргааны ерөнхий хуулийн 27, 73 дугаар зүйл, Газрын харилцаа, Барилга геодези, зураг зүйн газрын даргын 2010 оны 497 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр, төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамжийг хоёрдугаар, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах санал асуулгын хуудсыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Санал асуулгыг 2022 оны 09 дүгээр сарын 05-наас 2022 оны 10 дугаар сарын 05-ны дотор иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авч нэгтгэн багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэр 2022 оны 10 дугаар сарын 15-ны дотор хэлэлцүүлэн шийдвэр гаргаж ирүүлэхийг багийн Засаг дарга нарт даалгасугай.

3.Багийн Иргэдийн нийтийн хурлаас гаргасан шийдвэрийн дагуу төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж сумын бэлчээрийн менежментийн ажлын хэсгээр 2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор багтааж хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Сумъяа), Газрын даамал (Н.Хорлоо) нарт үүрэг болгосугай.


ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201181

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар
сарын 05-ны өдрийн 4/05 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүд

Б.Баяраа

(Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

Н.Хорлоо

(Газрын даамал)

С.Ганцэцэг

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Н.Жаргалсайхан

(Улсын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагч)

П.Батбаатар

(Байгаль хамгаалагч)

Ж.Лхагвасүрэн

(Уубулан 1 дүгээр багийн Засаг дарга)

Д.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат

(Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

оОо

СУМЫН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго: Сумын хөгжлийг дэмжихийн тулд газар нутгийн хэмжээнд хэчнээн хэмжээний газрыг хаана ямар зориулалтаар эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах, хамгаалах, нөхөн сэргээх нөөц боломжийг тодорхойлсны үндсэн дээр зүй зохистой оновчтой бүрэн дүүрэн ашиглалтыг бий болгох болон биологийн төрөл зүйл тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, зөв зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээний хөрөнгө оруулалт төсөв зардлын тооцоо дүгнэлт бүхий зураг төслийн аргаар тодорхойлсон баримт бичгийг боловсруулахад оршино.

Нэг: Төлөвлөгөө боловсруулах хугацаа:

2022 09 дүгээр сарын 05-наас-2022 оны 11 дүгээр сарын 01-ний дотор

Хоёр: Ажлын үе шат:

- 1.Бэлтгэл судалгаа
- 2.Газар дээр нь явж тодруулан судлах
- 3.Материал боловсруулалт болон төлөвлөх
- 4.Санал авч зөвшилцөх, батлуулах
- 5.Холбогдох зураг, хүснэгтэн баримт материал, тооцоо, тайланг бүрдүүлэх
- 6.Хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих гэсэн үе шатнаас бүрдэх ба дараах төрлийн суурь судалгаа, төлөвлөлтийн шийдлүүдийг багтаана.

Гурав: Хийгдэх ажил:

- 1.Удирдамжийн дагуу ажлын төлөвлөгөө гаргаж Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж ажиллах.
- 2.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санал асуулга авах
- 3.Багийн Иргэдийн нийтийн хурлын шийдвэр гаргуулах

Дөрөв : Гарах баримт бичиг:

- 1.Тайлбар бичиг буюу тайлан
- 2.Төлөвлөгөөний нэгдсэн зураг
- 3.Тооцоо, судалгааны материалууд (хүснэгт)
- 4.Төлөвлөлтийн талаархи саналын хувилбарууд

зургийн масштаб

1.Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн зураг 1:100000, 200000

2.Сумын төвийн суурьшлын бүсийн төлөвлөлтийн зураг 1:2000

3.Бэлчээр ашиглалтын суурь зураг 1:100000

Бэлчээрийн даацын буюу чадавхын зураг 1:100000

Бэлчээрийн уст цэгийн зураг 1:100000

Улирлын бэлчээрийн хуваарийн зураг 1:100000

_____оОо_____

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар сарын 05 -ны өдрийн АХТ-оор захирамжийн гуравдугаар хавсралт

ЖИНСТ СУМЫН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД
БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙГ ТУСГАХ ТАЛААР МАЛЧИД, МАЛЧДЫН
БҮЛГЭЭС АВАХ САНАЛЫН ХУУДАС

Санал өгсөн иргэний /овог нэр/ /нэр/ /багийн дугаар/

- 1.Өвөлжөө, хаваржаа, худаг уст цэг шинээр гаргах, эзэмших \газрын нэр, байршил \
.....
.....
.....
- 2.Бэлчээрийн ургац муудаж талхагдалд орж буй бэлчээр түүнтэй тэмцэх арга хэмжээний санал \газрын нэр, байршил \
.....
.....
.....
- 3.Малчдын бүлэг, баг дундын отрын нөөц нутаг бий болгох талаар \ малчдын бүлгийн нэр, газрын нэр байршил\
.....
.....
.....
- 4.Бэлчээр ашиглах талаар гарч байгаа маргаан, зөрчил \газрын нэр, ямар улирлын бэлчээр, маргалдагч тал \
.....
.....
.....
- 5.Та ган зуд тохиолдсон үед нүүдэллэх нутаг, хугацаа, малын тоо, төрөл зэргийг бичнэ үү? \газрын нэр, байршил\
.....
.....
.....
- 6.Цаг агаар хэвийн үед отор нүүдэл хийх хугацаа, малын тоо, төрөл \газрын нэр, байршил\
.....
.....
.....
- 7.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх хугацааны талаарх санал \газрын нэр, хугацаа\
.....
.....
.....
- 8.Танд бэлчээрийг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах чиглэлээр ямар төрлийн сургалт, зөвөлгөө, сурталчилгаа хэрэгтэй байна вэ?
.....
.....
.....
- 9.Танд бэлчээр ашиглалт, хамгаалалт, зохион байгуулалттай холбоотой санал, хүсэлтийн талаар бичнэ үү?
.....
.....
.....

Танд баярлалаа

ЖИНСТ СУМЫН 2023 ОНЫ ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНД
ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АСУУДЛЫГ ТУСГАХ ТАЛААР ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГУУДААС АВАХ САНАЛЫН ХУУДАС

Санал өгсөн иргэний /овог нэр/ /нэр/ /багийн дугаар/
Санал өгсөн хуулийн этгээдийн /нэр/ хаяг

1. Танайх сумын төвд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар өмчилж авсан уу ?
а. Тийм /асуулт 3т шилжинэ үү /
б. Үгүй

2. Үгүй бол газар өмчилж авах уу. /хаяг тодорхой бичнэ үү /

3.Шинээр эзэмших газар /ямар зориулалтаар, хаана газар эзэмших талаарх санал/ жич:
Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдана.

1. гэр бүлийн хамтын хэрэгцээнд болон аж ахуйн нэгж, байгууллага хүнсний ногоо, жимс
жимсгэнэ, таримал ургамал, тарих зориулалтаар эзэмших газар / засаг захиргаа нутаг
дэвсгэрийн харъяалал, байршил/

5.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалтаар газар
эзэмших /засаг захиргаа, нутаг дэвсгэрийн харъяалал, зориулалт, хэмжээ, байршил/

жич: Дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт явагдана.

- 6.Тухайн газрыг эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний хугацаа дуусаж байгаа эсэх

7.Геологийн хайгуулын болон ашиглалтын улмаас эвдэрч бохирдсон газар, түүнтэй тэмцэх, арга
хэмжээний санал /засаг захиргаа нутаг дэвсгэрийн харъяалал, байршил/

8.Элэгдэл эвдрэлд хүчтэй орсон атаршсан болон хамгаалах шаардлагатай тариалангийн газар,
түүнтэй тэнцэх арга хэмжээний санал /засаг захиргаа нутаг дэвсгэрийн харъяалал, байршил/

9.Суурьшлын бүсэд дэд бүтэц, нийгэм хангамжийн асуудлыг шийдвэрлэх талаар /засаг захиргаа
нутаг дэвсгэрийн харъяалал, байршил, дэд бүтэц, нийгэм хангамжийн ямар асуудлыг шийдвэрлэх/

10.Газрыг элэгдэл, эвдрэл, доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, түүнтэй тэмцэх арга
хэмжээний санал /засаг захиргаа нутаг дэвсгэрийн харъяалал, байршил/

- 11.Бусад шаардлагатай асуудлын талаар

Танд баярлалаа